



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/289

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” (2017-2021 он)-ийн эрүүл мэндийн салбарт хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д, эмчилгээ, оношилгоонд хэрэглэгдэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авахыг Эм үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, сөрөг үр дагавраас сэргийлэх хүн амын мэдлэг, хандлагыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/ нарт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбогдох оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, үр дүнг тооцож ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Л.Насанцэнгэл/-д тус тус даалгасугай.

3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн холбогдох арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, тайлангаа жил бүрийн 12 дугаар сард багтаан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Эрүүл мэндийг дэмжих сан, улс, орон нутгийн төсөвт үе шаттайгаар тусган санхүүжүүлж байхыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Төмөртоогоо/, Эдийн засаг, санхүүгийн хэлтэс /Б.Пүрэвсүрэн/-т тус тус зөвшөөрсүгэй.

080906

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ



Эрүүл-мэндийн сайдын
2017 оны 07 сарын 27-ны өдрийн
А. дугаар тушаалын хавсралт
2017.07.27

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦ НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021 он)

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран оролцох байгууллага
Нэг. Төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:				
1.1.	Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодистой холбоотой Монгол улсын нэгдэн орсон гэрээ, конвенцийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр томьёо, түүний орчуулгыг судлан шаардлагатай бол өөрчлөх саналыг ҮХАА-д хүргүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд	СЭМҮТ,	НЭМГ, ЭМЯ ХЗДХЯ, МУГХУСАЗ Зөвлөл, БСШУСЯ, ГХЯ,
1.2.	Гадаадын зарим улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд шаардлагатай бол эрүүл мэндийн асуудлын талаар санал боловсруулж, ҮХАА-д хүргүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд	СЭМҮТ	НЭМГ, ЭМЯ, ХЗДХЯ, ГХЯ, СЯ МУГХУСАЗЗөвлөл
1.3.	Олон улсад хэрэгжиж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн цогц удирдамж (КОЛОМБО хөтөлбөр)-ийг орчуулж, гарын авлага гаргах	2017-2018	СЭМҮТ	ЭМЯ, ГХЯ, БСШУСЯ, АНУ-ын ЭСЯ, КОЛОМБО хөтөлбөр
1.4.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант донтох эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандартууд болон опоидод донтох эмгэгийн диаморфины орлуулах эмчилгээний тусгайлсан стандартыг шинэчлэн боловсруулах	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд	СЭМҮТ	ЭТГ, ЭҮТГ, ЭМЯ, Стандартчилал хэмжил зүйн газар МУГХУСАЗ Зөвлөл
1.5.	Нийслэлд өөрийн хүсэлтээр сонгон эмчлүүлэх боломжтой мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант донтох эмгэгийн оношилгоо,	Хөтөлбөр хэрэгжүүлэх	СЭМҮТ	ЭТГ, ЭМЯ, НЗДТГ, НЭМГ, МУГХУСАЗ

	эмчилгээний эмчилгээ, үйлчилгээний шаардлага хангахуйц төв нэгийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	хугацаанд	Зөвлөл	Зөвлөл
Хоёр. Төрийн байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилтын хүрээнд:				
2.1.	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, эмчлэх, урьдчилан сэргийлэлтийн тусгай мэргэжилтнийг гадаад улсад бэлтгэх, тус ажлыг холбогдох байгууллага бүр дангаар болон нэгдсэн байдлаар хамтран зохион байгуулах, ОУ-ын эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн цогц удирдамжийг ашиглах, хэрэгжилтийг хангах үндэсний сургагч багш нарыг бэлтгэх шаталсан сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах	2017-2019	СЭМҮТ	НЭМГ, ЭМЯ, МУГХУСАЗ Зөвлөл, ГХЯ
2.2.	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын талаар салбар дундын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	2017-2018	СЭМҮТ	ЭҮТГ, НЭМГ, ХЗДХЯ, БСШУСЯ, ТЕГ, ГЕГ, ЦЕГ
2.4.	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт эм, бодисын экспорт, импорт, үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг эм хангамжийн байгууллага, эмийн сан, эм, бодисын түгээлт, хадгалалт, донтох эмгэгийн амбулаторын болон хэвтэн эмчлүүлэгчдийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас авч нэгтгэн тус хөтөлбөрийн Үндэсний хорооны Ажлын албанд хагас жил тутам хүргүүлэх тогтолцоог бий болгох	2017	ЭЭХХ, ЭҮТГ, СЭМҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМЯ, МУГХУСАЗ Зөвлөл
2.5.	Цагдаа, хил, гааль, тагнуулын байгууллагаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн талаар гадаад орны эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцоход оролцох, хамтран ажиллах, эрүүл мэндийн салбартай холбогдох нөхцөл байдлын мэдээллийг Ажлын албанд тогтмол хүргүүлж байх	2017-2018	СЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, ЗТХЯ, БСШУСЯ, ЦЕГ, ХХЕГ, ТЕГ, ГЕГ, МУГХУСАЗ Зөвлөл
2.6.	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын шалтгаант эмгэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төвийг эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн байгуулан, бүтэц орон тоог батлуулж, холбогдох зардлыг улсын төсөвт суулгах, Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын шалтгаант эмгэгтэй хүний албадан эмчилгээг ШШГЕГ-ын харьяа тусгай дэглэмтэй эмнэлэгт эмчилж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж хамтран ажиллах	2017	СЭМҮТ,	НЭМГ, ЭМЯ, БТГ, УТХАА, ХЗДХЯ, СЯ

Гурав. Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд:					
3.1.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг цагдаа, гааль, мэргэжлийн хяналт, шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтран жилд 2 удаа эрсдэл өндөртэй боомт, орон нутаг, сургуульд үе шаттай зохион байгуулахад оролцох, тайлан мэдээллийг Үндэсний хорооны Ажлын албанд хүргүүлэх	2017-2019	СЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ,	НЭМГ, ЭМЯ, ХЗДХЯ, БСШУСЯ, болон ТББ	
3.2.	Өсвөр үе, залуучууд, эрсдэл бүхий нийгмийн бүлгийг хамруулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбогдох дараах судалгааг мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан үе шаттайгаар зохион байгуулах. Үүнд: 3.2.1.хүн амын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний түвшинг тогтоох судалгаа 3.2.2.мансууруулах бодисын хэрэглэгчдийн судалгаа, тэдний дундах ХДХВ, тэмбүү, гепатит В,С вирусын халдварын эрсдэл, нөхцөл байдлын үнэлгээ 3.2.3.мансууруулах, сэтгэц идэвхт эм, бодистой холбоотой шүүх, сэтгэц, эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгсдийн асуудал 3.2.4.мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилт	2017-2018	НЭМҮТ, СЭМҮТ, Судалгааны байгууллага, бусад	Үндэсний хорооны Ажлын алба, ХЗДХЯ, БСШУСЯ,	
3.3.	Үндэсний хорооны Ажлын албанаас зохион байгуулсан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн агуулгад дүн шинжилгээ хийх бүрэлдэхүүнд оролцох, эрсдэлт бүлгийн залуучууд болон өсвөр үеийнхэнд мөлхөө сурталчилгаа хийх агуулга, хөтөлбөр, арга зүй боловсруулж, сурталчилах	2017-2018	СЭМҮТ, НЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	Үндэсний хорооны Ажлын алба, Хэвлэл, мэдээллийн болон судалгааны байгууллага	
3.4.	Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох зорилго бүхий төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаач нарыг хамруулсан эрдэм шинжилгээний хурал, семинар, симпозиумыг 2 жил тутам зохион байгуулахад оролцох	2017-2019	СЭМҮТ, НЭМҮТ	Үндэсний хорооны Ажлын алба	
3.5.	Мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий сургалтын хөтөлбөрт эрүүл мэндтэй холбогдох асуудлыг тусгах саналыг ҮХАА-д хүргүүлэх, бүх шатны сургуулийн сургалтад нэвтрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад оролцох	2017-2019	СЭМҮТ	НЭМГ, ЭМЯ, Үндэсний хорооны Ажлын алба, БСШУСЯ	

3.6	Гэр бүл, сургууль, ажлын байр, хэвлэл мэдээллийнхэн болон эрсдэлт бүлэгт чиглэгдсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, сургалт сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулахад оролцох	2017-2019	СЭМҮТ, НЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМЯ, МХАУТ, МҮЭ, МАОЭХ
3.7.	Мансууралтай тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах, түүний хор уршгийг иргэдэд ухуулан таниулах	2017-2019	СЭМҮТ НЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	ХЗДХЯ, МУГХУСАЗ Зөвлөл, ЭМЯ, БСШУСЯ, төрийн болон ТББ
3.8.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмгэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэлзүйн тусламж үзүүлэх ажлыг эрчимжүүлэх, олон улсын жишигт хүрсэн стандартыг баталж, хэрэгжүүлэх	2017-2019	СЭМҮТ	НЭМГ, ЭМЯ, МУГХУСАЗ Зөвлөл, СХЗГ
3.9.	Мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг илрүүлэх тест, тестрийг эмийн сангаар хөнгөлөлттэй үнээр зарж борлуулах, түүнийг импортоор оруулж ирэхэд холбогдох татвараас чөлөөлөх ажлыг зохион байгуулах;	2017-2018	ЭЭХХ, ЭҮТГ	СЭМҮТ, СЯ
3.10	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг бууруулах, эмчлэн сэргийлэх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах	2017-2019	НЭМҮТ, СЭМҮТ	НЭМГ, МУГХУСАЗ Зөвлөл
3.11	Шүүх, сэтгэцийн шинжилгээнд орж байгаа мансууралтай холбоотой гэмт хэрэгтэнд сэтгэл заслын зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулдаг болох	2019	СЭМҮТ	НЭМГ, ЭМЯ, ХЗДХЯ, ЦЕГ
3.12	Хорих ангиудад мансуурах гэмт хэрэгтэй холбогдсон хүмүүжигч нарт сэтгэл заслын эмчилгээ хийх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2019	СЭМҮТ	НЭМГ, ХЗДХЯ, ЦЕГ
Дөрөв.Холбогдох албан хаагчдыг мэргэшүүлэх, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх зорилтын хүрээнд:				
4.1.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх, шинжлэх орчин үеийн багаж хэрэгсэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмгэгийг эмчлэх эм, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах, тэдгээрийг импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх саналыг СЯ-д хүргүүлэх	2017-2019	ЭЭХХ, ЭҮТГ ХОХ, БТГ	СЭМҮТ, МУГХУСАЗ Зөвлөл, СЯ, ЭМЯ, ХЗДХЯ, ЦЕГ, ГЕГ
4.2.	Ачаалал ихтэй, эрсдэл өндөртэй хилийн боомт газруудад мансууруулах	2017	СЭМҮТ	ЭЭХХ, ЭҮТГ

	<p>эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэхэд шаардлагатай анхан шатны болон том оворын ачаа, тээш, машин техник шалгах зориулалт бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгааг гаргах, судалгааны дүнг үндэслэн худалдан авах, нийлүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахад оролцох</p>			<p>ХОХ, БТГ МУГХУСАЗ Зөвлөл ХХААХҮЯ, ХЗДХЯ, СЯ</p>
4.3.	<p>Тусламж үйлчилгээ, зөвлөгөө болон сэтгэл зүйч, нарийн мэргэшлийн эмч, шинжээч, техникийн ажилтан бэлтгэх чиглэлээр гадаад улсад тусгай мэргэжилтэн бэлтгэх, холбогдох зардлыг улсын төсөвт тухай бүр тусгаж шийдвэрлэх</p>	2017-2019	СЭМҮТ	<p>НЭМГ, ХЗДХЯ, СЯ</p> <p>ЭЗСХ</p>
4.4.	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий ажилтнуудын нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээнд санал хүргүүлэх, хамтран ажиллах</p>	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд	СЭМҮТ	<p>НЭМГ,ТЗУГ МУГХУСАЗ Зөвлөл СЯ, ХЗДХЯ, ХНХЯ</p>

-oOo-